



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/396

Есөнбулаг

┌ Эрхийн төрөл өөрчлөх тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2021 оны А/121 дүгээр захирамжаар 8208004590 дугаар нэгж талбарт Тотал дистрибюшн ХХК (5167647) нь эзэмшиж байгаа газрын эрхийн төрөл өөрчлөх хүсэлтийн дагуу эрхийн төрлийг ашиглах эрхийн төрлөөр өөрчлөн 5 жилийн хугацаатай ашиглуулсугай.

2.Газар ашигласан Тотал дистрибюшн ХХК-ий мэдээллийг Газрын удирдлагын нэгдсэн системд холбогдох журмын дагуу бүртгэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т зөвшөөрсүгэй.

3.Газар ашиглагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/121 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

